



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар Д/1509

Улаанбаатар хот

Г Баянзүрх дүүргийн Нэмүүлэн өрхийн Г
эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,247,375 /дөрвөн сая хоёр зуун дөчин долоон мянга гурван зуун далан тав/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Нэмүүлэн өрхийн эрүүл мэндийн төв /Г.Чанцалмаа/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс, 5 нэр төрлийн 4,168,000 /дөрвөн сая нэг зуун жаран найман мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, 1 нэр төрлийн 79,375 /далан есөн мянга гурван зуун далан тав/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устган, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Нэмүүлэн өрхийн эрүүл мэндийн төв /Г.Чанцалмаа/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115060001567

Нийслэлийн Өмчийн Ашиглалт удирдлагын газрын
 даргын 2020 оны 12 сарын 22 өдрийн 8/569
 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Нэмүүлэн өрхийн эрүүл мэндийн төв

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
Машин тоног төхөөрөмж											
1	Зөөврийн компьютер	9	ш	1	1,280,000.00	1,280,000.00	1,280,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	татах
2	Шээсний хагас анализатор	7	ш	1	800,000.00	800,000.00	800,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	татах
3	Цусны даралт хэмжигч	6	ш	1	838,000.00	838,000.00	838,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	татах
4	Шинжилгээний төхөөрөмж Центрифуги	7	ш	1	500,000.00	500,000.00	500,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	татах
5	Урсдаг самбар	7	ш	1	750,000.00	750,000.00	750,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	татах
Машин тоног төхөөрөмжийн дүн			ш	5	4,168,000.00	4,168,000.00	4,168,000.00	-			
Тавилга эд хогшил											
6	Эмнэлгийн ор	13	ш	1	79,375.00	79,375.00	79,375.00	-	Эвдэрсэн	актлах	устгах
Машин тоног төхөөрөмжийн дүн			ш	1	79,375.00	79,375.00	79,375.00	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						4,247,375.00	4,247,375.00	-			
Үүнээс: Устгах хөрөнгө			ш	1		79,375.00	79,375.00	-			
Татан төвлөрүүлэх хөрөнгө			ш	5		4,168,000.00	4,168,000.00	-			